

Гэр бүлийн дундын өмч ба гэрлэлтийн гэрээ

Marital Property and Marriage Contract

Даваадоржийн Болорчимэг

Хууль зүйн ухааны магистр (LL.M.)

Улаанбаатар хот, Монгол Улс.

davaadorjbolorchimeg@gmail.com

© D.Bolorchimeg, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)
(CC BY-NC 4.0)

[Товч утга]

Гэр бүлийн гишүүний хамтран өмчлөх өмчлөлийн зүйлд үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, үнэт цаас, ногдол хувь зэрэг өргөн хүрээтэй хөрөнгүүд бий болж шүүхээс гэр бүлийн гишүүдийн дундын хөрөнгийн эрхийг хуваарилахдаа зөвхөн хуулиар хатуу тогтоон зохицуулахаас илүү сайн дураараа, чөлөөт зарчмын үндсэн дээр байгуулсан гэрээг үндэслэн шийдвэрлэх явдал үр нөлөө өндөртэй болсоор байна.

Австрали болон Швед улсууд нь гэр бүлийн дундын эд хөрөнгийг зохицуулах зохицуулалтаараа дэлхийд тэргүүлэх орнуудын нэг гэж тооцогддог бөгөөд эдгээр улсуудын гэр бүлийн гишүүнд ногдох дундын эд хөрөнгийн харилцааг хууль болон гэрээгээр зохицуулсан туршлагыг өөрийн улсын Гэр бүлийн тухай 2023 оны хуулийн төсөл болон одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 1999 оны Гэр бүлийн тухай хуультай харьцуулан судаллаа.

Иймд энэхүү харилцааг илүү нарийвчлан журамлахын зэрэгцээ тусгайлсан хууль болгон зохицуулах нь манай улсад эрх зүйн хөгжлийн хувьд хүрэх зорилго болж байна.

[Түлхүүр үг]

Дундаа хамтран өмчлөх хөрөнгө, гэр бүлийн өмч, өмчийн эрх, өмчийн хуваарилалт, гэрлэлтийн гэрээ, салалт, дундын өмчийн зохицуулалт, хууль зүйн гэрээ.

I. Оршил

Гэр бүлийн эрх зүй нь хувийн эрх зүйн суурь харилцаа байдлаар олон улсад тодорхойлогдож байна.

Монгол Улсын 1999 оны гэр бүлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд тус хуульд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь гэр бүлийн харилцаанд тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн гэхээс илүүтэй салбарын харилцааг зохицуулсан буюу бусад хуулийн шинэчлэлийг дагалдан өөрчлөлт оруулсан төдий явдал юм¹.

Монгол Улсад гэр бүлийн маргааныг оновчтой шийдвэрлэх, гэр бүлийн гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал нэн чухал болсныг тоо баримт харуулж байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэрийн тоо баримтаас дурдвал 2024 онд гэр бүлийн эрх зүйн нийт маргаан 5913 байгаагийн гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан 3983, хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой маргаан 1924, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцохтой холбоотой маргаан 22, эцэг тогтоохтой холбоотой маргаан 310 байна².

Манай улс 595 олон талт гэрээнд нэгдэн орсноос гэр бүлийн харилцаа, гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрхийг хамгаалах зорилготой Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Сайн дурын үндсэн дээр гэрлэх болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай конвенц зэрэгт нэгдэн орж, соёрхон баталжээ.

Бусад улсын жишгээс үзвэл, гэр бүлийн хөрөнгийн эрх буюу гэрлэгчдийн дундаа хэсгээр өмчлөх, эсхүл хамтран өмчлөх эд хөрөнгийн эрхийн зохицуулалтыг сайжруулах түүнийг гэрээгээр зохицуулах нь гэр бүлийн эрх зүйн харилцаанд диспозитив аргыг хэрэглэх онолын асуудал болно. Энэ нь манай улсын Иргэний хуулийн 132 дугаар зүйлийн 1-д зааснаар “Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан тохиолдолд ногдох хөрөнгийг энэ хуульд нийцүүлэн байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулж болох”-ыг тусгасан нь гэрээ байгуулах, гэрээний эрх, үүрэг талуудад үүсгэх гэрлэлтийн гэрээний зохицуулалтаар өмчлөгч туйлын эрхээ хамгаалуулах боломжтойг харуулсан байна.³

Гэрлэгсэд болон гэр бүлийн гишүүдийн хуваарьт болон дундын

¹ https://lawforum.parliament.mn/project/490/#1698454537/хуулийн_танилцуулга/

² Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн тайлан. Уб., 2025. 2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ

³ Ц.Давхарбаяр “Эдийн баялагийн эрх-Эд юмсын эрх” Уб., 2017 он. 133 дахь тал.

эд хөрөнгийн эрхийг гэрлэлтийн гэрээгээр хамгаалж зохицуулах улс орнуудын дотроос хамгийн өндөр хөгжсөн улсад Швед⁴, Австрали⁵ улс багтдаг бөгөөд эрх зүйн бүлийн төлөөлөл болгон эдгээр хоёр улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзлээ.

Гэр бүлийн дундын өмч нь гэрлэлтийн үед гэрлэгчдийн хамтран эзэмшиж буй бүх хөрөнгө, эд зүйлийг хамардаг. Энэ нь гэрлэгчдийн хамтран хийсэн ажлын үр дүн, эд хөрөнгө үүсэхээс эхлээд гэрлэлтийн өмнө болон дараа гэрлэгчдийн бүхий л өмчийн харилцааг зохицуулна. Гэр бүлийн дундын өмчийг улс орнууд өөр өөрийн эрх зүйн тогтолцоонд хэрхэн зохицуулах нь харилцан адилгүй байна.

Монгол улсын гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга / 2023 оны хуулийн “төсөл” дэх гэрлэлтийн гэрээний талаарх зохицуулалтууд нь гэр бүлийн харилцааг олон улсын жишигт нийцүүлэн зохицуулах, орхигдсон буюу хийдлийг арилгахад гэр бүлийн тухай хуулийн төслийн 22, 23 дугаар зүйлүүд дээр нарийвчлан журамласан байгааг дурдах нь зүйтэй.

II. Өмчийн тухай ойлголт

A. “Дундаа хамтран өмчлөх” болон “дундаа хэсгээр өмчлөх” тухай

Өмч гэдэг нь аливаа этгээдэд байж болох үнэлж болох бүхнийг хэлдэг. Товчоор хэлбэл материаллаг оюун санааны үнэ цэнэтэй зүйл бүхнийг өмч гэж ойлгож болно. Өмч нь биет болон биет бус хэлбэртэй. Өмч нь нийгмийн харилцаанд баялгийг эзэмших, үйлдвэрлэх, хуваарилах явцад бий болох бөгөөд хүмүүсийн хооронд үүсэж буй эдийн засгийн харилцааг өмчийн харилцаа гэнэ⁶.

Өмчийн субъект нь хувь хүн, гэр бүл, нийгмийн бүлэг, хөдөлмөрийн хамт олон, тухайн нутаг дэвсгэрийн хүн ам, ард түмэн, бүх түвшний байгууллагууд орно. Өмч нь иргэний эрх зүйн харилцаанд эд хөрөнгө гэх нэр томъёонд хамаарч зохицуулагддаг. Эд хөрөнгө нь дотроо үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө болж хуваагдах бөгөөд энэхүү хөрөнгийг ИХ-ийн 101.1 дэх хэсэгт зааснаар өмчлөгч хэрэгжүүлэх эрхтэй байдаг.

Өмчлөх эрх нь анхдагч болон үүсмэл байдлаар үүсдэг. Анхдагч үндэслэл нь хуульд заасны дагуу буюу өмнөх өмчлөгчийн хүсэл зоригоос үл хамааран өмчлөх эрх үүснэ. Үүсмэл үндэслэл нь

⁴ Swedish Government Offices. 2005. Swedish Civil Code (Swedish Code of Statutes 1734:1). Retrived from <http://www.government.se>

⁵ Australiam Government. 1975. Family Law Act 1975. Retrived from <http://www.Legislation.gov.au>

⁶ Батцоож Хонгор “Өмч ба өмчийн харилцаа,” Slide share, 2016 оны 12 сарын 9, <https://www.slideshare.net/slideshow/ss-69980433/69980433>

өмчлөгчийн хүсэл зоригийн дагуу шинэ өмчлөгчид өмчлөх эрх үүсэхийг ойлгоно⁷. Өөрөөр хэлбэл өмч гэдэг нь материаллаг болон оюун санааны үнэ цэнэтэй хуулиар хамгаалагдсан бүхнийг хэлнэ. Өмч нь хувийн, нийтийн, холимог гэсэн төрөлтэй бөгөөд захиран зарцуулах, ашиглах, эзэмших эрхтэй тэр зүйлийг хэлнэ⁸.

Өмч түүний ангилал

Ромын үеийн сэтгэгчид “res private” буюу иргэний гүйлгээн дэх эд баялаг, “res publicae” буюу иргэний гүйлгээнд хамааралгүй эд баялаг гэж ангилж, “res publicae” нийтийн өмч гэсэн ойлголтыг илэрхийлж иржээ. Үүнд ой мод, агаар, зам гүүр гэх мэтийг ойлгож байжээ⁹. Орчин үед хуульч Жереми Уолдрон өөрийн бүтээлдээ “өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх арга механизмын эхний шат бол өмчийн ерөнхий тогтолцооны хүрээнд тэдгээрийг ангилах, ерөнхийг тусгай аргументаас салгаж ойлгоход оршиж байна гэжээ¹⁰.

Дээрхээс үндэслэн дундын өмчийг тухайн өмчийн зориулалт, түүнийг эзэмших, ашиглах субъектын тоо зэргээс хамаарч дундын өмч гэх ойлголт гарч ирж байна. Монгол Улсын Иргэний хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-д “Хуульд зааснаар эсхүл хэлцлийн үндсэн дээр хоёр буюу түүнээс дээш этгээд хөрөнгийг дундаа хэсгээр буюу хамтран өмчилж болно” гэж заасан. Хувийн өмчийн эрх зүйн нэг хэсэг болохын хувьд дундын өмчийн ойлголт, агуулгыг тодорхойлж үзэх нь танин мэдэхүйн болон үүсэх хэлбэр, онцлог шинж, зохицуулалтын арга, цаашид гарах эрх зүйн үр дагаврыг тогтооход ач холбогдолтой юм.

Дундын өмчлөлийг дээрх онол арга зүйд үндэслэн дараах 2 төрөлд ангилж хуваан үзэж байна. Үүнд: дундаа хэсгээр өмчлөх, дундаа хамтран өмчлөх

1. Дундаа хэсгээр өмчлөх:

Дундаа хамтран өмчлөх ойлголтыг гаргаж ирэхийн тулд үүсэх хэлбэр, онцлог шинж, зохицуулалтын арга, цаашид гаргах эрх зүйн үр дагаврын талаар авч үзэх шаардлага үүснэ. Дундаа хэсгээр хамтран өмчлөх эрх зүйн зохицуулалт нь Иргэний хуулийн 108 зүйлд зааснаар субъектын хувьд хоёр буюу түүнээс дээш этгээд, оруулсан хөрөнгийн хувь хэмжээ нь тодорхой байдгаас хамааран захиран зарцуулах эрх нь тодорхой байдаг.

Дундаа хэсгээр өмчлөх эрхтэй этгээд бүр дундын өмчөөс өөрт

⁷ Т.Мөнхжаргал, Монгол Улсын Иргэний Эрх зүй Ерөнхий анги. Уб., 2000. 53 дахь тал.

⁸ Мөн тэнд.

⁹ Г.Агар. Хувийн өмчийн онол. Уб., 2009, 26 дахь тал.

¹⁰ Мөн тэнд.

ногдох хувиа өөрийн үзэмжээр захиран зарцуулах эрхтэй байдаг¹¹. Гэхдээ оролцогчдын уг эд хөрөнгийг бий болгох арвижуулахад хувь оролцоо нь өөр бол ногдох хувийг хэлцлээр тодорхойлж болно. Мөн тухайн өмчөө салгах боломжгүй, түүндээ мэдэгдэм сайжруулалт хийсэн бол түүнд ногдох хувь, оруулсан хувь нэмрийн хэмжээгээр нэмэгдэнэ. Хэрэв уг ногдох хувийн талаар оролцогчид тохиролцож чадаагүй бол ногдох хувиа тогтоолгохоор шүүхэд хандаж болно¹².

Дундаа хэсгээр өмчлөх эрх дуусгавар болох: Дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгийг хуваах, түүнээс өмчөө салгаж авахыг дундаа хэсгээр өмчлөгч этгээдүүд хэлэлцэн тохиролцсоноор, эсвэл шүүхийн шийдвэрээр, харилцан тохиролцсоноор аль аль оролцогчдоо хохирол багатай шийдвэрлэж болно. Өмчийн эрх дуусгавар болох ерөнхий журамд хамаарах боловч дундын өмчөө хуваах буюу салгаж авахтай холбогддог онцлогтой. Дундын өмчийг хуваахад дундын өмчлөгчдийн эрх дуусгавар болдог бол дундын өмчөөс хэсгээр өмчлөх эрхээ салгаж авахад өмчөө салгаж авч буй этгээдийн хэсгээр өмчлөх эрх дуусгавар болно. Дундаа хэсгээр өмчлөх эрх дуусгавар болох үндэслэл арга нь өөр байдаг. Дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгийг хуваах түүнээс өмчөө салгаж авахыг дундаа хэсгээр өмчлөгч этгээдүүд хэлэлцэн тохиролцсоноор, эсвэл шүүхийн шийдвэрээр гүйцэтгэж болно¹³.

2. Дундаа хамтран өмчлөх:

Хоёр буюу түүнээс дээш этгээд оролцоно. Хамтран өмчлөгч этгээдүүд тухайн эд хөрөнгөд оруулсан хувь хэмжээ тодорхойгүй, оногдох хувь хэмжээг нь шууд тодорхойлох боломжгүй, Хамтдаа эзэмшиж, хамтдаа ашиглаж, хамтдаа захиран зарцуулах эрхтэй өмч байдаг. Дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийг өмчлөгч бүрийн ногдох хувийг тодорхойлсны дараа тэнцүү хэмжээгээр ногдох хувийг тодорхойлно. Харин хууль буюу гэрээгээр өөр журам тогтоогоогүй бол өмчлөгч бүрийн ногдох хувь адил байна гэсэн зарчмыг баримтална. /Жишээ: Гэрлэгчдийн хөрөнгийн эрхийн зарим харилцааг гэрээгээр зохицуулж болно ИХ-ийн 132, 133 зүйл/ Энэхүү өмчид: а. Газар-“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд: газрыг гэр бүлийн хэрэгцээнд тодорхой зориулалтаар гэр бүлийн гишүүдэд өмчлүүлнэ” гэж зохицуулсан. Газрыг үл хөдлөх эд хөрөнгийн хувьд худалдах, арилжих, өвлүүлэх, бэлэглэх, барьцаалахдаа Иргэний хуулийн “ Гэр бүлийн хөрөнгийн эрх” хэсгийн зохицуулалтыг хэрэглэдэг. /ИХ 128 зүйл /¹⁴

¹¹ Иргэний хууль. 2002. 108.4-р зүйл

¹² Иргэний хууль. 2002. 108-р зүйл

¹³ Б.Баттөмөр. Монгол Улсын Иргэний эрх зүй Ерөнхий анги. Уб., 2020. 76 дахь тал.

¹⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага. Дундын өмчлөлийн эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. Уб., 2016. 7-8 дахь тал.

Б. Гэр бүлийн дундын өмч

Гэр бүлийн дундын өмч нь дундаа хамтран өмчлөх эрхийн үндсэн төрөл юм. Гэр бүлийн харилцаа нь шууд утгаараа гэрлэгчид гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөтэй холбоотой харилцаа. Гэр бүлийн гишүүдийн хоорондох тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаа гэж ерөнхий хувааж болно. Харин гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгөтэй холбоотой харилцааг дотор нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө, гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө гэж хуваана. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн харилцаа нь гэр бүлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан “Гэрлэлт” байхыг шаарддаг онцлогтой. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд хуульд зааснаар 7¹⁵ төрлийн эд хөрөнгө хамаарч байна. Гэр бүлийн гишүүний дундын эд хөрөнгийг хуваах, гишүүнд ногдох хэсгийг мөн гэр бүлийн гишүүний хуваарьт эд хөрөнгийг тодорхойлох зэргийг Иргэний хуулиар¹⁶ нарийвчлан зохицуулж байна.

III. Гэрлэлтийн гэрээний зохицуулалт, харьцуулалт

А. Гэрлэлтийн гэрээний ойлголт, зохицуулалт

Гэр бүл бологсад өөрсдийн өмчлөх эрхтэй холбоотой гэрээ байгуулах явдал нь эртний Ромоос гаралтай байх бөгөөд Ромын эрх зүй дэх гэр бүлийн хөгжлийн хоёрдугаар шат буюу тэгш эрхт гэр бүлийн шатанд гэрлэгчид гэр бүл болохдоо гэрээ байгуулдаг болсон байна. Монгол Улсын 1926 оны анхны иргэний хуульд “Эр эм хоёр аливаа хогшлийн тухай завсар дор хууль ёсны гэрээ хэлэлцээр байгуулж болно” гэж зохицуулж байжээ. Гэрлэлтийн гэрээ нь Иргэний эрх зүйн харилцааны эд хөрөнгийн харилцааг зохицуулах бөгөөд эд хөрөнгийн бус амины эрх болох эцэг эхээ халамжлах, хүүхдийн тоо, хүүхдэд нэр өгөх, гэх мэт амины харилцаануудад заншлын ба ёс суртахууны хэм хэмжээг хэрэглэх нь зохимжтой болно¹⁷.

Гэрлэлтийн гэрээний үндсэн зорилго нь гэрлэгчдийн хоорондын эдийн засгийн харилцааг ил тод, зохицуулалттай болгох үүднээс чухал үүрэг гүйцэтгэдэг. Тус гэрээ нь:

- Гэр бүлийн дундын өмчийн хуваарилалтыг урьдчилан тохирох,
- Гэрлэлтийн үед үүсэх эдийн засгийн хариуцлагыг зохицуулах,
- Гэрлэгчдийн хооронд хөрөнгийн эрхийн маргаан үүсэхээс сэргийлэх,

¹⁵ Иргэний хууль. 2002. 126.2-р зүйл

¹⁶ Мөн тэнд.

¹⁷ Н.Энхцэцэг, “Гэр бүлийн эрх зүй дэх эд хөрөнгийн харилцааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” Уб., 1999. 35 дахь тал.

- Гэрлэлтийн дараа үүсэж болох хариуцлагыг урьдчилан шийдвэрлэх зэрэг зорилгыг агуулдаг. Гэрлэлтийн гэрээ нь гэрлэгчдийн өмчийн харилцааг тодорхой болгож, гэр бүлийн дундын өмчийг хэрхэн хуваарилах тухай шийдвэрлэх боломжийг олгодог. Гэрлэлтийн гэрээгээр гэрлэгчид хоорондын маргаан үүсэх үед хуулийн хамгаалалт авах боломж байдаг.

Гэрлэлтийн гэрээ нь хэд хэдэн төрлийн байж болох бөгөөд гэрлэгчдийн хүсэл, гэр бүлийн нөхцөл байдлаас хамаарч өөр өөр хэлбэртэй байж болно. Жишээ нь: Өмчийн тусгаарлах гэрээ. Гэрлэгчид өөрсдийн өмчийг гэрлэсний дараа хуваах зорилгоор энэхүү гэрээг байгуулдаг. Энэ нь тус бүрийн эзэмшдэг хөрөнгийг хуваарилахгүй байх боломжийг олгодог.

Дундын өмчийн гэрээ: Гэрлэгчид хамтран эзэмших, хуваарилах хөрөнгийг гэрлэлтийн гэрээгээр тохиролцох боломжтой. Энэ гэрээгээр тэдний хамтын өмчлөлийн эд хөрөнгийг хэрхэн хуваарилах талаар урьдчилан тохиролцоно.

Олон улсад гэрлэлтийн гэрээ нь улс орнуудын эрх зүйн системд харилцан адилгүй байна. Зарим улсад гэрлэлтийн гэрээ нь заавал байх ёстой бол, зарим оронд зөвхөн гэрлэгчдийн хүсэлтийн дагуу хийх боломжтой байдаг. Зарим улсад гэрлэлтийн гэрээ нь гэр бүлийн дундын өмчийн хуваарилалтын зөвхөн гэрлэлтийн үед буюу гэрлэлт дуусах үед тохиролцох боломжтой бол, зарим улсад гэрлэлтийн гэрээг гэрлэгчид гэрлэлтийн явцад ч байгуулж болдог.

Б. Швед /Ром-Германы эрх зүйн бүл/

Шведийн эрх зүйн систем нь Ромын эрх зүйн бүлийн уламжлал дээр үндэслэсэн¹⁸. Гэрлэлтийн харилцааг гэрлэлтийн гэрээ, хууль эрх зүй, тэгш эрх, нийгмийн тогтвортой байдал зэргийг харгалзан шийдвэрлэсэн гэдгээрээ Швед улсыг гэр бүлийн эрх зүйн механизм нь хамгийн сайн зохицуулагдсан улс орнуудын тоонд оруулдаг.

Шведийн гэр бүлийн хөрөнгө, өмчийн эрх, гэрлэлтийн гэрээний асуудлыг Aktenskapsbalken (Гэрлэлтийн хууль, 1987) болон Bodelningslagen (Хөрөнгийн хуваарилалтын хууль, 1987), мөн Sambolagen (Сонгомол хосуудын хууль 2003)-иар тус тус зохицуулдаг байна. Харин Formogenhetstratt буюу Шведийн Иргэний хууль нь манай улс шиг гэр бүлийн дундын эд хөрөнгийн асуудлуудыг шууд шийдвэрлэдэггүй харин эд хөрөнгийн эзэмшил, эд хөрөнгийг шилжүүлэх, гэрээний ерөнхий асуудлуудыг хамран зохицуулдаг хууль болно.

Aktenskapsbalken (Гэрлэлтийн хууль) нь Шведийн Иргэний хуулийн хэсэг биш тусдаа хууль бөгөөд гэрлэлт болон гэрлэлт цуцлах

¹⁸ Clark, David S. Comparative Law: A Handbook. Oxford University Press. 2012.

үеийн гэр бүлийн харилцааг зохицуулдаг хууль. Aktenskapsbalken (Гэрлэлтийн хууль)-ийн 7 дугаар бүлэг (Bodelning) заалтууд нь гэрлэсний дараах хамтран эзэмших эд хөрөнгийг хэрхэн хуваах тухай зохицуулдаг. Жишээ нь Гэрлэлтийн хуулийн 7 дугаар зүйлийн 1¹⁹-д “Гэрлэлтийг дуссаны дараа гэрлэгчдийн хөрөнгө хуваарилагдах ёстой. Хөрөнгийн хуваарилалт нь гэрлэлт дууссаны дараа аль болох хурдан хийгдэнэ” гэж мөн хуулийн 7 дугаар зүйлийн 3-т “Гэрлэгчид гэрлэлтийн гэрээгээр тодорхой хөрөнгийг хуваарилалтад оруулахгүй байх эсвэл бусадтай хуваарилах ёстой хөрөнгийг хуваарилалтаас хасах, эсвэл тусгаарлаж болно” гэж гэрлэлтийн гэрээ болон хуулийн зохицуулалтаар шийдвэрлэх боломжийг зохицуулж өгсөн байна.

Ерөнхийд нь энэ хуулиар гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваарилахдаа гэр бүл цуцлахад хэний буруутайгаас үүсэлтэйг шийдвэрлэхээс гадна гэр бүлийн бусад гишүүдийн оногдох хөрөнгө шалтгааныг зохицуулдаг байна.

Bodelningslagen (Хөрөнгийн хуваарилалтын хууль, 1987) нь гэрлэлт болон гэрлэлтийн хугацаанд хамтран эзэмшсэн эд хөрөнгийн хуваарилалтын хуваарилах аргачлалыг зохицуулсан хууль юм. Энэ хуулиар гэрлэлт цуцлалтын асуудлыг биш гэрлэгчдийн эд хөрөнгийн эрх болох хуваарьт хөрөнгө, гэр бүлийн дундын хөрөнгийн асуудлыг нарийвчлан зохицуулсан хууль юм²⁰.

Sambolagen (Сонгомол хосуудын хууль 2003) нь гэрлээгүй хосууд буюу сонгомол хосуудын эд хөрөнгийн харилцааг зохицуулах бөгөөд тэдний хамтран эзэмшдэг эд хөрөнгө, өмчийн асуудлыг шийддэг. Энэ хуулиар зөвхөн гэрлэлтийн бүртгэлгүй хосуудын гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрхийн асуудлыг шийдвэрлэдэг байна.

Шведийн хуулиуд гэрлэлтийн гэрээгээр хамтран өмчлөх эд хөрөнгийг зохицуулах ач холбогдол нь хосуудын гэрлэлтийн үед хамтран эзэмшиж буй эд хөрөнгийн хуваарилалтыг өөрчлөх боломж гэж хардаг. Мөн гэрлэлтийн гэрээний тусламжтайгаар эд хөрөнгийн зохицуулалтаа хувийн зохицуулалт хийх боломжийг хосуудад олгодог.

В. Австрали /Англо Саксоны эрх зүйн бүл/

Австрали нь Англи Саксоны эрх зүйн бүлд хамаарах тул энэ бүлийн эрх зүйн тогтолцоо нь тухайн улсын хууль зүйн системээс хамаардаг бөгөөд гэр бүлийн харилцаа, өмчийн эрхийн асуудлыг зохицуулахад харьцангуй өөр өөр байдаг²¹. Австрали нь гэр бүлийн

¹⁹ Swedish Code of Status (SFS 1987:230), Aktenskapsbalken [Marriage Code], Chapter 7, Sections 1. <http://www.riksdagen.se/en/documents -and-laws/laws/>

²⁰ Swedish Code of Status (SFS). (1987:230). Bodelningslagen [Law on Division of Property], Chapter 1, Section 1 <http://www.riksdagen.se/en/documents -and-laws/laws/>

²¹ М.Энхболд. Эрх зүйн системүүд: Харьцуулсан судалгаа. ШУА-ийн хэвлэлийн

дундын эд хөрөнгийг зохицуулах зохицуулалтаараа дэлхийд тэргүүлэх орнуудын нэг гэж тооцогддог.

Австрали улсад Family Law Act 1975 болон Property (Relationships) Act 1984 буюу Эд хөрөнгийн хуваарилалтын хууль гэсэн хоёр хууль гэр бүлийн дундын эд хөрөнгө болон гэрлэлтийн гэрээг зохицуулдаг байна. Харин Австралид тусгайлсан Иргэний хууль (Civil Law) байхгүй ч тодорхой төрлийн эрх зүйн асуудлуудыг зохицуулдаг гэр бүлийн тухай хууль болон эд хөрөнгийн хуваарилалтын хуулиудаар тус тус зохицуулагдаж байна. Гэр бүлийн хууль (Family Law Act 1975) нь гэрлэсэн хосуудын дундын эд хөрөнгө болон гэр бүлийн гишүүдийн ногдох хөрөнгийг хэрхэн хуваарилах талаар зохицуулна. Property (Relationships) Act 1984 нь гэрлэлтээ батлуулаагүй хамтран амьдрагч хосуудын хэрхэн хуваарилах талаар зохицуулдаг хууль юм.

Австралид салж буй хосууд гэрлэлтийн гэрээ (prenuptial agreement) ашиглах нь харьцангуй түгээмэл байдаг байна. Австрали дахь гэрлэлтийн гэрээ нь “Binding Financial Agreements” (BFA)²² гэж нэрлэгддэг бөгөөд хосууд гэрлэлтийн өмнө, гэрлэлтийн дараа эсвэл салалт болох үед эд хөрөнгийн асуудлыг зохицуулахад ашигладаг.

Гэрлэлтийн гэрээний ач холбогдол нь шүүхийн оролцоог багасгах, амжилттай салалт явагдах, урьдчилан сэргийлэх, хуулиас илүү хувийн тохиролцоо хийх зэрэг давуу талтай байдаг. Гэхдээ Австралийн гэрлэлтийн гэрээ нь шүүхийн хяналттай бөгөөд зөвхөн хос хоёрын хооронд зөвшилцсөн, гэрээний бүрэн төгс байдал хангагдсан тохиолдолд хүчинтэй байна. Энэ нь гэрээг шүүх баталгаажуулдгаас шүүхийн процессын хугацаа уддаг, зардал ихтэй зэрэг сул талтайгаас гадна шүүх зарим тохиолдолд илт шударга бус тохиролцоо байвал гэрээг хүлээн зөвшөөрөхгүй байж болдог байна²³.

IV. Дүгнэлт

Нийгмийн үндсэн институт болох гэр бүл түүний харилцааг зохицуулж буй хэм хэмжээ цаг үеийнхээ шаардлагыг хангаж байх нь чухал юм. “Гэр бүл”-ийн харилцааг орчин үед зохицуулах арга хэлбэр нь уламжлалт ойлголтоосоо нэлээдгүй хувьсан өөрчлөгдсөөр байна. Нөгөөтэйгүүр манай улсын гэр бүлийн тухай хуулиар гэр бүл гэдэг нь зөвхөн гэрлэгчид бус тэдгээртэй хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүд болох аав, ээж, ах, эгч, дүү, төрлийн хүмүүсийг хамруулан ойлгодог тул өмчийн харилцаа нь нэгэн адил гэр бүлийн гишүүдийг

газар. Уб., 2015.

²² Family Law Act 1975, Chapter 5, Part 8 (Binding Financial Agreements) <http://www.legislation.gov.au>

²³ Smith, J. “Financial Agreements in Australian Family Law: Legal and Practical Considerations” Australian Family Law Review, vol.34, no.2, 2019 pp. 121-134

бүхэлд нь хамааруулан зохицуулагдаж байна.

Бусад улсын жишгээс үзэхэд, гэр бүлийн хөрөнгийн эрх буюу гэрлэгчдийн дундаа хэсгээр өмчлөх, эсхүл хамтран өмчлөх эд хөрөнгийн эрхийн зохицуулалтыг сайжруулах шаардлагаар 2023 оны Гэр бүлийн тухай хуулийн төслийн загварыг Чех, Польш, ОХУ, Исланд, Шинэ-Зеланд, БНСУ, Япон, ХБНГУ, БНХАУ, Канад, Финлянд зэрэг улсуудын гэр бүлийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон Монгол Улсын шүүхийн статистик тоо, судалгаанд үндэслэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 11 бүлэг, 94 зүйлтэй боловсруулсан байна.

Судлаач миний хувьд гэрлэгсэд болон гэр бүлийн гишүүдийн хуваарьт болон дундын эд хөрөнгийн эрхийг гэрлэлтийн гэрээгээр хамгаалж зохицуулах улс орнуудын дотроос хамгийн өндөр хөгжсөн улсад Швед, Австрали улс багтдаг учир эрх зүйн бүлийн төлөөлөл болгон эдгээр хоёр улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн билээ.

Судалгааны ажлын үр дүнд:

1. Энэ сэдэв нь гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг ойлгох, гэрлэлтийн гэрээг хэрэгжүүлэх, гэр бүлийн өмчийн зохицуулалтыг сайжруулахад чухал ач холбогдолтой болно. Гэр бүлийн дундын эд хөрөнгө ба гэрлэлтийн гэрээний асуудлыг олон улсад Иргэний хуулиар бус тусгайлсан хуулиар зохицуулж байгаа нь энэхүү харилцаа нь илүү нарийвчилж журамлах шаардлагатай болохыг харуулж байна.

2. Гэр бүлийн дундын өмч ба гэрлэлтийн гэрээний асуудал нь гэр бүлийн хөрөнгийн харилцаа, өмчийн зохицуулалт, гэрлэлтийн дараах хариуцлага зэрэг олон чухал асуудлыг хамарч байна. Гэрлэлтийн гэрээ нь гэр бүлийн өмчийн хуваарилалтыг урьдчилан тохиролцох боломжийг олгох бөгөөд гэрлэгчдийн хоорондын эд хөрөнгийн харилцааг харилцан тохиролцож хуваарилах боломжийг салж буй хосуудад олгож байна.

3. Швед, Австрали орнууд нь гэр бүлийн дундын эд хөрөнгийн харилцааг зохицуулахдаа позитив тогтоосон хуулиараа гэрлэгчдийн болон гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины эрхийг хамгаалах чиглэлд хөгжсөн байх бөгөөд Монгол улсын шинэчлэн найруулсан Гэр бүлийн тухай 2023 оны хуулийн төсөл энэ чиглэлд бичигдсэн байгааг харж болохоор байна.

Харин Гэрлэлтийн гэрээг Швед улс нь хосуудын эд хөрөнгийн эрхийг хуульд зааснаар зохицуулахаас гадна гэрлэгчдийн хуулиас өөр хэлбэрээр зохицуулах шийдлийг гаргаж өгсөн байна.

Австрали дахь гэрлэлтийн гэрээ нь “Binding Financial Agreements” (BFA) гэж нэрлэгддэг бөгөөд хосууд гэрлэлтийн өмнө, гэрлэлтийн

дараа эсвэл салалт болох үед эд хөрөнгийн асуудлыг зохицуулахад ашиглаж байгаагаараа энэхүү Гэрлэлтийн гэрээний агуулгыг эд хөрөнгө гэж харахаас илүү тохиролцоо гэж үзэн хэрэглэж байгаа нь эрх зүйн хөгжлийн хувьд илүү хөгжсөн гэж дүгнэж болох юм.

4. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль нь хувийн эрх зүйн асуудлуудыг зохицуулж байгаа суурь хуулиудын нэг бөгөөд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль 1999 онд батлагдсан. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн эрх зүй нь хувийн эрх зүйн суурь харилцаа байдлаар олон улсад тодорхойлогдож байна.

Гэр бүлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд тус хуульд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь гэр бүлийн харилцаанд тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн гэхээс илүүтэй салбарын харилцааг зохицуулсан буюу бусад хуулийн шинэчлэлийг дагалдан өөрчлөлт оруулсан байна. Монгол Улсын хувьд хууль батлагдаж байсан үе буюу 1999 оноос хойш гэрлэх, гэрлэлт цуцлах, хүүхдийн эрх, хууль ёсны эрх ашиг хөндөгдөх, зөрчигдөх, сэргээх зэрэг харилцаа ихсэж байгаа бөгөөд үүнээс үүсэх үр дагаврыг төдийлөн нарийвчлан зохицуулаагүй байсныг 2023 оны Гэр бүлийн тухай хуулийн төслөөр илүү нарийвчлан зохицуулсан байгаа нь сайшаалтай байна. Хууль болон гэрлэлтийн гэрээ нь гэр бүлийн эдийн засгийн харилцааг тогтвортой байлгаж гэрлэгчдийн эрхийг хамгаалах чухал эрх зүйн хэрэгсэл юм.

Иймд энэхүү харилцааг илүү нарийвчлан журамлахын зэрэгцээ тусгайлсан хууль болгон зохицуулах нь манай улсад эрх зүйн хөгжлийн хувьд хүрэх зорилго болж байна.

[Ном зүй]

- Мөнхжаргал Т, Монгол Улсын Иргэний Эрх зүй Ерөнхий анги, УБ, 2000 он
- Дугармаа А, Гэр бүлийн эрх зүй, УБ, 2016 он
- Ц.Давхарбаяр, Эдийн баялагийн эрх-Эд юмсын эрх, УБ, 2017 он
- Агар Г, Хувийн өмчийн онол, УБ, 2009 он
- Баттөмөр Б, Монгол Улсын Иргэний эрх зүй Ерөнхий анги, УБ, 2020 он
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Дундын өмчлөлийн эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, 2016 он
- Энхцэцэг Н, “Гэр бүлийн эрх зүй дэх эд хөрөнгийн харилцааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”, 1999 он
- Энхболд М, Эрх зүйн системүүд: Харьцуулсан судалгаа. УБ:ШУА-ийн хэвлэлийн газар, 2015 он
- Э.Эгиймаа, Гэр бүлийн эрх зүй дэх гэрлэлтийн гэрээ, /магистрын зэрэг горилсон дипломын ажил / УБ, 2018 он
- Б.Урангоо, Гэрлэгчдийн дундын эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа, /магистрын дипломын ажил / УБ, 2017 он
- Clark, David S. Comparative Law: A Handbook. Oxford University Press, 2012.
- Smith, J. “Financial Agreements in Australian Family Law: Legal and Practical Considerations” Australian Family Law Review, vol.34, no.2, 2019 pp
- Австралийн гэр бүлийн хууль 1975
- Монгол Улсын Иргэний хууль 2002
- Монгол Улсын гэр бүлийн тухай хууль 1999
- Шведийн гэр бүлийн тухай хууль 1987
- Шведийн сонгомол хууль 2009
- <https://www.slideshare.net/slideshow/ss-69980433/69980433>
- <http://www.government.se>
- <http://www.Legislation.gov.au>
- Swedish Code of Status (SFS). (1987:230). Bodelningslagen [Law on Division of Property], Chapter 1, Section 1 <http://www.riksdagen.se/en/documents-and-laws/laws/>
- Family Law Act 1975, Chapter 5, Part 8 (Binding Financial Agreements)
- <http://www.legislation.gov.au>

[Abstract]

Marital Property and Marriage Contract

Davaadorj Bolorchimeg

Master of laws (LL.M.)

Ulaanbaatar, Mongolia

As a wide range of assets, such as real estate, movable property, securities, and dividends, are created in jointly owned property of family members, it is more effective for the court to decide on the basis of voluntary and free agreements rather than strictly regulated by law.

Australia and Sweden are considered to be one of the leading countries in the world in terms of regulation of joint family property, and the relationship of joint property per family member as well as the practices regulated by law and contract in these countries, have been studied in comparison with their country's draft Family Law 2023 and the current Family Law 1999.

Therefore, regulating this relationship in more detail, as well as regulating it is a spatial law, is goal achieved in terms of legal development in our country.

[Keywords]

Common property, marital property, property rights, property distribution, marriage contract, divorce, joint property arrangements, legal agreements.